

## ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

2024 оны 05-р сарын 14-ны өдөр

### 1. Өмгөөллийн үйлчилгээ авах ажлын даалгавар

“Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-ийн нэхэмжлэлтэй, Орхон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарт холбогдох улсын байцаагч нарын 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 07/25-02/122/04 дугаартай актыг хучингүй болгуулах нэхэмжлэхийн шаардах бүхий захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 35 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 123 дугаартай магадлалыг Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1-д заасан хууль хэрэглээний зөрүүг арилган, 123.2.2-т заасан хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, 123.2.3-т заасан хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, 123.2.4-т заасан эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэсэн үндэслэлүүдээр Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд нэхэмжлэгч буюу “Эрэнэтийн Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хэлэлцэх хяналтын шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх,

### 2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл:

|                                                            |                                                                                                                                                         |
|------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа: | 2024 оны 05-р сарын 16-ны өдрийн 09цаг 00 минутанд хүлээн авна.                                                                                         |
| Материал хүлээн авах хаяг:                                 | “ЭДЦС” ТӨХК-ийн өөрийн байр, 401 тоот, Бичиг хэргийн ажилтанд битүүмжлэх эсхүл <a href="mailto:info@erdenetpp.mn">info@erdenetpp.mn</a> хаягаар ирүүлэх |
| Холбоо барих утас:                                         | 7035-0951                                                                                                                                               |
| Материал нээх хугацаа, хаяг, байршил                       | 2024 оны 05-р сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутанд “ЭДЦС” ТӨХК-ийн өөрийн байр,                                                                        |
| Үнийн санал авах дээд үнэ                                  | 20,000,000 /хорин сая/ төгрөг                                                                                                                           |
| Тавигдах шаардлага:                                        | Захиргааны хэрэгт дагнаж өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан бол давуу тал болно.                                                                        |

#### Жич:

- Оролцогч сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрдүүлж ирүүлэх
- Оролцогч нь зард заасан хугацаанд материалаа өөрийн биеэр болон и-мэйл хаягаар ирүүлэх, хоцорсон оролцогчийн саналыг хүлээн авахгүй.
- Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.
- Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

**Хаяг:** Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК өөрийн байр,

**Холбогдох мэргэжилтэн:** М.Ванчиндорж /хуулийн зөвлөх/